

ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД ХЭРГИЙН САЙД
ГЭР БҮЛ, ХӨДӨЛМӨР НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН САЙДЫН
ХАМТАРСАН ТУШААЛ

2025 оны ... дугаар
сарын өдөр

Дугаар/.....

Улаанбаатар хот

Журам батлах тухай

Хүн худалдаалахтай тэмцэх тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.2.4- дэх хэсгийг
ТУШААХ НЬ:

1.Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогч хүүхдэд хүүхэд
хамгааллын үйлчилгээ үзүүлэх журмыг хавсралтаар баталсугай.

2.Энэ тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Гэр бүл, хөдөлмөр,
нийгмийн хамгааллын яамны Гэр бүлийн бодлогын газар /..... /-т, Хууль зүй,
дотоод хэргийн яамны Бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар /..... /-т, Монгол
Улсад Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийн ажлын алба
/...../-д тус тус даалгасугай.

ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД
ХЭРГИЙН САЙД

ГЭР БҮЛ, ХӨДӨЛМӨР,
НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН САЙД

ХҮН ХУДАЛДААЛАХ ГЭМТ ХЭРГИЙН ХОХИРОГЧ ХҮҮХДЭД ХҮҮХЭД ХАМГААЛЛЫН ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭХ ЖУРАМ

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1.1. Энэ журмын зорилго нь хүн худалдаалах гэмт хэргийн хохирогч хүүхдэд хүүхэд хамгааллын үйлчилгээ үзүүлэх харилцааг зохицуулна.

1.2. Хүүхэд хамгааллын үйлчилгээг үзүүлэхдээ Хүн худалдаалахтай тэмцэх тухай хууль, Хүүхэд хамгааллын тухай хууль, Хүүхдийн эрхийн тухай хууль, Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хууль, Хувь хүний нууцыг хамгаалах тухай хууль болон бусад Монгол Улсын олон улсын гэрээ, үндэсний хууль тогтоомжийг дагаж мөрдөнө.

1.3. Хүн худалдаалахтай тэмцэх тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.2 дахь заалтад заасан хүн худалдаалах гэмт хэргийн хохирогч /цаашид “хохирогч хүүхэд” гэх/ нь Хүн худалдаалахтай тэмцэх тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1 болон Хүүхэд хамгааллын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан үйлчилгээнд хамрагдана.

1.4. Хүүхэд хамгааллын тухай хуулийн 3 дугаар зүйлд зааснаар Монгол Улсын нутагт дэвсгэрт болон хилийн гадна байгаа хохирогч хүүхдэд үйлчилгээ үзүүлнэ.

1.5. Хохирогч хүүхдэд үйлчилгээ үзүүлэх байгууллага нь Хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний баталсан Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогч хүүхдэд үйлчилгээ үзүүлэх салбар дундын хамтарсан багтай хамтран ажиллана.

1.6. Х НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН САЙД

охирогч хүүхдэд үйлчилгээ үзүүлэхэд дараах зарчмыг баримтална.

1.6.1. Хүүхдийн эрхийн тухай хуулийн 4 дүгээр зүйлд заасан;

1.6.2. Хүүхэд хамгааллын тухай хуулийн 5 дугаар зүйлд заасан;

1.6.3. Хүн худалдаалахтай тэмцэх тухай хуулийн 4 дүгээр зүйлд заасан;

1.6.4. Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хуулийн 4 дүгээр

зүйлийн 4.1.11, 4.1.12 дахь заалтад заасан.

ХОЁР. УДИРДЛАГА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

2.1. Салбар дундын хамтарсан баг /цаашид “Хамтарсан баг” гэх/ нь хохирогч хүүхдэд үйлчилгээ үзүүлэх оролцогч талуудыг нэгдсэн удирдлага, мэргэжил арга зүйгээр ханган ажиллана.

2.2. Хохирогч хүүхдэд хүүхэд хамгааллын үйлчилгээг үндэсний түвшинд хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага, орон нутгийн түвшинд хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал хариуцсан байгууллага үзүүлнэ.

2.3. Хүүхэд хамгааллын мэдээллийн санд (Primero) хохирогч хүүхдийг бүртгэх, хүүхэд хамгааллын үйлчилгээг хөтлөх бөгөөд Хамтарсан баг хэрэгжилттэй танилцах, шаардлагатай тохиолдолд Хамтарсан багийн нарийн бичгийн дарга хяналт тавина.

2.4.Хохирогч хүүхдэд энэ журмын 1.3-т заасан үйлчилгээг үзүүлэхдээ Хүн худалдаалахтай тэмцэх тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.11 дэх хэсэгт заасан магадлан итгэмжлэгдсэн хуулийн этгээдтэй хамтран ажиллаж болно.

ГУРАВ. ХОХИРОГЧ ХҮҮХДЭД ҮЗҮҮЛЭХ ХҮҮХЭД ХАМГААЛЛЫН ҮЙЛЧИЛГЭЭ

3.1.Хохирогч хүүхдэд энэхүү журмын 1.3-т заасан хүүхэд хамгааллын үйлчилгээ үзүүлэхдээ Хүүхэд хамгааллын тухай хуулийн 15 дугаар зүйлд заасан кейс менежментийн үе шатны дагуу үйлчилгээг төлөвлөн хүргэнэ.

3.2.Үйлчилгээ үзүүлэхдээ нөхцөл байдлын үнэлгээний дүгнэлтэд үндэслэх бөгөөд кейс менежментийн төлөвлөгөөг боловсруулахдаа эцэг эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч болон хүүхдийн саналыг харгалзана.

3.3.Магадлан итгэмжлэгдсэн төрийн бус байгууллага үйлчилгээ үзүүлж байгаа тохиолдолд кейс менежерээр ажиллаж, кейс менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх бөгөөд орон нутгийн хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал хариуцсан байгууллага болон Хамтарсан багийн нарийн бичгийн дарга мэргэжлийн удирдлагаар хангаж, хяналт тавина.

3.4.Оршин суух хаяг тодорхойгүй хохирогч хүүхдийн үндсэн харьяалалыг тогтоох арга хэмжээг авах, түүнтэй холбоотой кейс менежер томилохыг хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага шийдвэрлэнэ.

3.5.Хохирогч хүүхдэд шуурхай тусламжийн болон хамгаалах, нөхөн сэргээх үйлчилгээ үзүүлэхдээ Хүн худалдаалахтай тэмцэх тухай хуулийн 12.2-т заасны дагуу эрх бүхий байгууллагаас баталсан холбогдох журмуудыг баримтална.

3.6.Хүн худалдаалах хэргийн хохирогч, хохирогч байж болзошгүй хүүхэдтэй холбоотой хэргийн мөрдөн шалгах ажиллагаанд Хүүхэд хамгааллын тухай хуулийн 29.6-д заасан хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаан дахь хүүхэд хамгааллын журмыг баримтлах бөгөөд Хүүхдийн эрхийн хууль зүйн хороотой мэдээлэл солилцон хамтран ажиллана.

3.7.Хохирогч хүүхэдтэй гэмт хэргийн талаар ярилцлага хийх тохиолдолд форензик ярилцлагын аргыг эзэмшсэн нийгмийн ажилтан эсхүл сэтгэл зүйчийг байлцуулна.

3.8.Хүүхэд, түүний гэр бүлийн гишүүн хэл яриа, сонсголын бэрхшээлтэй эсхүл монгол хэл мэдэхгүй, тусгай хэрэгцээ шаардлагатай бол Хүүхэд хамгааллын хуулийн 15 дугаар зүйлийн 15.3 дахь хэсгийг баримтлана.

3.9.Хохирогч хүүхдийг илрүүлэх, шуурхай тусламжийн үйлчилгээ үзүүлэх

3.9.1.Хохирогч хүүхдийг илрүүлэх, шуурхай тусламжийн үйлчилгээ үзүүлэхдээ Хүн худалдаалахтай тэмцэх тухай хуулийн 13 дугаар зүйл, Хүүхэд хамгааллын тухай хуулийн 16, 17, 18 дугаар зүйлд заасныг баримтална.

3.9.2.Хохирогч хүүхдийг илрүүлэхдээ ажиглалт, ярилцлага, стандарчлагдсан тест бусад аргачлалыг ашиглан ба Хүүхэд хамгааллын тухай хуулийн 18 дугаар

зүйлийн 18.8 дахь хэсэгт заасан журмын дагуу эрсдлийн болон нөхцөл байдлын үнэлгээг хийнэ. Үнэлгээг хийхдээ хүүхэд, гэр бүлийн нийгмийн ажилтан, сэтгэл зүйч, цагдаагийн алба хаагч бусад мэргэшсэн хүн, нарийн мэргэжлийн шинжээч, мэргэжилтнийг оролцуулж болно.

3.9.3.Хохирогч хүүхдэд цагдаагийн алба хаагч, нийгмийн ажилтан хамтран аюулгүйн зэргийн болон эрсдэлийн үнэлгээ хийх бөгөөд хүүхдийг тухайн орчинд үлдээх боломжгүй нөхцөл үүссэн бол эрсдэлтэй орчноос тусгаарлаж, нэг цэгийн үйлчилгээний төв болон түр хамгаалах байранд байрлуулна.

3.9.4.Хохирогч хүүхдийн аюулгүй байдлыг хангахдаа эцэг эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчийн зөвшөөрөлтэйгээр, долоогоос дээш насны хүүхдэд танилцуулж, зөвшөөрөл авна.

3.9.5.Хохирогч хүүхдийн аюулгүй байдлыг хангаж, эрсдэлт орчноос тусгаарлах арга хэмжээ авахад асран хамгаалагч, харгалзан дэмжигч нь тухайн хүүхдийн эсрэг гэмт хэрэг үйлдсэн гэх үндэслэл байгаа бол тэдний зөвшөөрлийг шаардахгүй.

3.9.6. Нэг цэгийн үйлчилгээний төв болон түр хамгаалах байранд байрласан хохирогч хүүхдэд эрүүл мэндийн тусламж үйлчилгээ, шинжилгээ, оношилгоо хийлгэх, сэтгэл зүйн зөвлөгөө, сэтгэл заслын үйлчилгээ, хууль зүйн зөвлөгөө, боловсролын үйлчилгээг кейс менежментийн төлөвлөгөөний дагуу үзүүлэх бөгөөд хамтарсан багийн нарийн бичгийн дарга эсхүл орон нутгийн хүүхэд, гэр бүлийн асуудал хариуцсан байгууллага мэргэжлийн удирдлагаар хангаж, хяналт тавьж, Хамтарсан багтай мэдээлэл солилцож ажиллана.

3.9.7.Хохирогч хүүхэд, түүний гэр бүлд сэтгэл зүйн ба сэтгэцийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлэхэд мэргэжлийн байгууллага, мэргэшсэн сэтгэл зүйчтэй хамтран ажиллах бөгөөд MNS 7065:2025 Хүүхдэд сэтгэл зүйн тусламж үйлчилгээ үзүүлэх нийтлэг шаардлага болон холбогдох журам, стандартыг мөрдөнө.

3.10.Хохирогч хүүхдэд хамгаалах, нөхөн сэргээх үйлчилгээ үзүүлэх

3.10.1.Хохирогч хүүхдэд Хүн худалдаалахтай тэмцэх тухай хуулийн 12, 13 дугаар зүйл, Хүүхэд хамгааллын тухай хуулийн 8.2-т заасан хамгаалах, нөхөн сэргээх үйлчилгээг үзүүлэхдээ гэр бүлийн орчинд эсхүл гэр бүлээс тусдаа орчинд үзүүлнэ.

3.10.2.Нөхцөл байдлын үнэлгээгээр гэр бүлийг дэмжих тогтолцоог сайн, хүүхэд зан үйлийн өөрчлөлтгүй, амиа хорлох эрсдэлгүй, сэтгэл зүйн тусламж, үйлчилгээ үзүүлж байгаа сэтгэл зүйч, эмч, мэргэжилтний дүгнэлт, хүүхдийн саналыг харгалзан гэр бүлийн орчинд үйлчилгээг үзүүлнэ.

3.10.3.Гэр бүлтэй ажиллахдаа хүүхэд, гэр бүлийн болон халамжийн нийгмийн ажилтан, боловсролын нийгмийн ажилтнууд хамтран ажиллах бөгөөд тэдгээрийн үүрэг, оролцоог нарийвчлан тусгасан гэрээ байгуулан ажиллана.

3.10.4.Хүүхдийн зан үйлийг засах, нийгэмшүүлэх, амьдрах ухааны боловсрол олгох, хөгжлийг дэмжих үйлчилгээ үзүүлэхэд мэргэжлийн байгууллагуудтай хамтран ажиллана.

3.10.5.Хүүхдэд боловсрол нөхөн олгох, суурь боловсрол эзэмшүүлэх ажлыг орон нутгийн боловсролын байгууллагатай хамтран шийдвэрлэх бөгөөд хүүхдэд тохиромжтой хэлбэрээр сургалтын хувилбарыг сонгоно. Боловсролын сургалтын орчинд хүүхдийн хувийн мэдээллийн нууцлалыг хадгална.

3.10.6.Гэр бүлийн орчинд хохирогч хүүхдэд үйлчилгээ үзүүлэх явцад заналхийлсэн, дарамтлах, айлган сүрдүүлэх, мөрдөн мөшгих зэрэг эрсдэл учирвал аюулын зэргийн үнэлгээг хийж гэр бүлээс нь тусгаарлах арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.

3.10.7.Гэр бүлээс тусдаа орчинд хамгаалах, нөхөн сэргээх үйлчилгээг үзүүлэхдээ Хүүхэд хамгааллын тухай хуулийн 9, 11, 12, 13 дугаар зүйлийг мөрдөн ажиллана.

3.10.8.Энэ журмын 3.10.7-д заасан гэр бүлээс тусдаа орчинд буюу хохирогч хүүхдийг төрөл садны болон асралт гэр бүлд асруулах эсэхийг Хүүхэд хамгааллын тухай хуулийн 9.3-т заасны дагуу хүүхдийн санал, мэргэжлийн байгууллага болон хүүхэд, гэр бүлийн нийгмийн ажилтны дүгнэлт, хүүхдийг асран хамгаалах гэр бүлийн хүсэлт, зөвшөөрөл, бусад эрсдэлийг харгалзан Хамтарсан багийн хурлаар хэлэлцэн шийдвэрлэнэ.

3.10.9.Хохирогч хүүхдийг төрөл садны асаргаа, асралт гэр бүлд холбон зуучилсан тохиолдолд хүүхэд, гэр бүлийн нийгмийн ажилтан, халамжийн нийгмийн ажилтан дэмжлэг үзүүлж, тогтмол хяналт тавьж ажиллана

3.10.10.Хүүхэд асрах хувилбарт үйлчилгээ үр дүнгүй, эсхүл аюул, эрсдэл үүссэн, үйлчлүүлэгч татгалзсан, Хүүхэд хамгааллын тухай хуулийн 12.5, 12.6-д заасан нөхцөл үүссэн тохиолдолд Хамтарсан багийн хурлаар хэлэлцэн асрамж халамжийн байгууллагын үйлчилгээнд хамруулах эсэхийг шийдвэрлэнэ.

3.10.11.Асрамж, халамжийн байгууллагад байрлуулсан тохиолдолд хүүхдийн хувийн нууцлалыг хадгалах, орчиндоо дасан зохицох, бусад хүүхэдтэй ээнэгшихэд тухайн байгууллагын багш, нийгмийн ажилтан дэмжлэг үзүүлж, хариуцан ажиллана.

3.10.12.Гэр бүлээс тусдаа орчинд үйлчилгээ авах хугацаанд хохирогч хүүхдийн гэр бүлтэй кейс менежментийн төлөвлөгөө боловсруулан ажиллаж, үр дүнд хүрсэн тохиолдолд хүүхдийг гэр бүлд эргэн нэгтгэх ажлыг хийнэ.

3.10.13.Хамгаалах, нөхөн сэргээх үйлчилгээ үзүүлэх байгууллага нь мэргэжлийн удирдлагын хүрээнд кейс шийдвэрлэлтэд үүссэн бэрхшээл, алдаа дутагдлыг нэн даруй арилгах арга хэмжээ авч хэрэгжүүлнэ.

3.10.14.Кейс менежер, хууль ёсны төлөөлөгч, өмгөөлөгч, өөр ажилд шилжсэн, чөлөөлөгдсөн, хуулиар хүлээсэн чиг үүргээ хэрэгжүүлээгүй тохиолдолд Хамтарсан багаар хэлэлцэж, дараагийн кейс менежерийг томилж, хувийн хэргийг хүлээлгэн өгнө.

3.10.15. Хамтарсан баг нь Хүүхэд хамгааллын тухай хуулийн 20 дугаар зүйлд заасны дагуу үйлчилгээний явц, үр дүнг хянах, үнэлэх арга хэмжээ авч ажиллана.

3.10.16. Хохирогч хүүхдийн кейсийг хаахдаа Хүүхэд хамгааллын тухай хуулийн 21 дүгээр зүйлийг баримтлах бөгөөд Хамтарсан багаар хэлэлцэж шийдвэрлэнэ.

3.10.17. Кейсийг эргэн хянах, үнэлэх, эрсдэлтэй тохиолдолд дахин нөхцөл байдлын үнэлгээ хийж ажиллахыг орон нутгийн хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал хариуцсан байгууллага хариуцна.

3.10.18. Хохирогч болон түүний гэр бүлийг нэг кейс гэж үзэж, бүртгэл, үйлчилгээний талаарх мэдээллийг санд хөтлөх бөгөөд Хамтарсан баг тухай бүр хяналт тавьж, дэмжлэг үзүүлж ажиллана.

3.10.19. Хохирогч хүүхдэд үүсгэсэн хувийн хэргийг Хүүхэд хамгааллын тухай хуулийн 15.4 дэх хэсэг болон MNS 6949:2021 Нийгмийн ажлын үйлчилгээний нийтлэг шаардлагын дагуу бүрдүүлж, хадгаламжийн нэгж үүсгэн архивлана.

3.11. Хүүхэд хамгааллын урьдчилан сэргийлэх үйлчилгээ

3.11.1. Хүүхэд хамгааллын тухай хуулийн 14 дүгээр зүйлд заасан урьдчилан сэргийлэх үйлчилгээг хохирогч хүүхэд, түүний гэр бүл, асран хамгаалагч, харгалзан дэмжигч, асралт гэр бүлд үзүүлнэ.

3.11.2. Урьдчилан сэргийлэх үйлчилгээнд сургалт, зөвлөгөө, дэмжих бүлэг, амьдрах ухааны сургалт, хүүхдийн оролцооны клуб, дугуйлан, хүүхдийн хөгжлийг дэмжих болон нийгэмшүүлэх хөтөлбөр зэрэг хамаарна.

3.11.3. Хохирогч хүүхдийг энэ журмын 3.10.4, 3.10.11, 3.11.1-т заасан үйлчилгээнд хамруулахдаа гэр бүлийн орчинд үйлчилгээ авч байгаа бол эцэг эх, асран хамгаалагч, гэр бүлээс тусдаа орчинд үйлчилгээ авч байгаа бол асралт гэр бүл, үйлчилгээ үзүүлж байгаа байгууллагын нийгмийн ажилтан хүүхдийг хүргэх, хүлээн авах ажлыг зохион байгуулна.

3.11.4. Хүүхэд хамгааллын урьдчилан сэргийлэх үйлчилгээг кейс менежер гүйцэтгэж, Хамтарсан баг хяналт тавина.

3.11.5. Хүүхдийн хөгжлийг дэмжих болон нийгэмшүүлэх хөтөлбөрийг магадлан итгэмжлэгдсэн болон мэргэжлийн байгууллага, мэргэшсэн хүнээр гүйцэтгүүлэхдээ хувь хүний нууцлал, онцлог, хэрэгцээ шаардлагыг хамгаалан гэрээ байгуулан ажиллана.

3.11.6. Үйлчилгээ авч буй хохирогч хүүхдэд шинээр эрсдэл бий болох тохиолдолд нэн даруй үйлчилгээ үзүүлж, кейс менежментийн төлөвлөгөөнд өөрчлөлт оруулж Хамтарсан багаар хэлэлцэн батлана.

ДӨРӨВ. САНХҮҮЖИЛТ

4.1. Хүүхэд хамгааллын тухай хуулийн 52 дугаар зүйл, Хүн худалдаалахтай тэмцэх тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.5, 16 дугаар зүйл, Засгийн газрын 2024 оны 236 дугаар тогтоолоор баталсан Хүүхэд хамгааллын үйлчилгээг санхүүжүүлэх аргачлал, үйлчилгээний нэг хүүхдэд ногдох дундаж зардлын нормативыг мөрдөж санхүүжүүлнэ.

4.2.Хохирогч хүүхдэд үзүүлэх үйлчилгээний санхүүжилтийг Хүүхэд хамгааллын тухай хуулийн 52.2, 52.3-д заасны дагуу төлөвлөж, 52.1.2, 52.6-д заасны дагуу шаардагдах зардлыг жил бүрийн төсөвтөө тусган санхүүжүүлнэ.

4.3.Хохирогч хүүхдэд үзүүлэх хүүхэд хамгааллын үйлчилгээний бусад зардлыг Хүүхэд хамгааллын тухай хуулийн 52.1.3, 52.1.4-т заасан эх үүсвэрээс санхүүжүүлнэ.

4.4.Хохирогч хүүхдэд үзүүлэх хөгжлийг үйлчилгээний санхүүжилтийг Хүүхдийн эрхийн тухай хуулийн 6.6-д заасан Хүүхдийн хөгжлийг дэмжих үйлчилгээг санхүүжүүлэх аргачлал, үйлчилгээний зардлын нормативын дагуу төлөвлөж, санхүүжүүлж болно.

ТАВ.ХЯНАЛТ, ҮНЭЛГЭЭ, ТАЙЛАГНАХ

5.1. Салбар дундын хамтарсан баг нь Хүүхэд хамгааллын тухай хуулийн 20 дугаар зүйлд заасны дагуу үйлчилгээний явц, үр дүнг хянах, үнэлэх арга хэмжээ авч ажиллана.

5.2.Салбар дундын хамтарсан багийн эрх бүхий гишүүн Хүүхэд хамгааллын мэдээллийн санд оруулсан үйлчилгээний мэдээлэлтэй тухай бүр танилцаж ажиллах бөгөөд кейс менежер хохирогч хүүхдэд үзүүлсэн үйлчилгээний явцыг кейс тус бүрээр гаргаж, Салбар дундын хамтарсан багт улирал тутам хүргүүлнэ.

5.3.Хохирогч хүүхдэд хүүхэд хамгааллын үйлчилгээ үзүүлэхэд Хүүхэд хамгааллын тухай хуулийн 53 дугаар зүйлд заасны дагуу хүүхэд, гэр бүл хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага, 55 дугаар зүйлд заасны дагуу хүүхдийн эрхийн улсын байцаагч үйл ажиллагаатай танилцах, зөвлөн туслах, үр нөлөөг үнэлж дүгнэн хяналт тавьж ажиллана.

5.4.Салбар дундын хамтарсан баг кейс тус бүрт хяналт тавьж, шаардлагатай тохиолдолд газар дээр нь очиж шалгах ажлыг зохион байгуулах бөгөөд удирдлага, зохион байгуулалтын дэмжлэг үзүүлнэ.

5.5.Олон улсын төрөлжсөн байгууллага, магадлан итгэмжлэгдсэн төрийн бус байгууллага, хуулийн этгээдээр хүүхдийн эрхийн болон хүүхэд хамгааллын талаар хөндлөнгийн хяналт, шинжилгээ хийлгэж болно.

5.6.Салбар дундын хамтарсан баг хохирогч хүүхдэд үзүүлсэн үйлчилгээний тайланг хагас жил тутам, хяналт шинжилгээ үнэлгээний тайланг жил тутам хүн худалдаалахтай тэмцэх, урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах, мэргэжлийн удирдлагаар хангах чиг үүрэг бүхий Дэд зөвлөлд танилцуулна.

ЗУРГАА.БУСАД

6.1.Энэхүү журмыг зөрчсөн болон үйлчилгээ үзүүлэх явцад хүүхдийн эрхийг зөрчсөн, мэргэжлийн болон ёс зүйн алдаа гаргасан байгууллага, албан хаагчид холбогдох хууль тогтоомжид заасан хариуцлага хүлээлгэнэ.